

Ерөнхийлөгчийн Тамгын Газар



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛГААР ХЭРЭГЖИЖ БУЙ “ЭРҮҮЛ
МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД БАЯНХОНГОР АЙМАГТ
ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙН ТАЙЛАН**

2022. 10 сар

АГУУЛГА

- НЭГ. УДИРТГАЛ
- ХОЁР. ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ
- СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
 - НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
- ГУРАВ. ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ
- ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
- ДӨРӨВ. НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР
- БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРОО
- ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:
- УЛСЫН ТӨВ НЭГДҮГЭЭР ЭМНЭЛЭГ
 - ХӨГЖЛИЙН ЗУУН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
- ЗУРГАА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ
- ХӨГЖЛИЙН ЗУУН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

НЭГ.УДИРТГАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, орон нутгийн онцлогийг тусгах, тэдний оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхийлөгчийн тамгын газраас Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний нээлттэй өдөрлөгийг 2022 оны 10 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулав. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үндсэн 4 бүрэлдэхүүн болох зохистой хооллолт, эрүүл зан үйл, нийтийн биеийн тамир, эрүүл мэндийн боловсрол чиглэлийг сурталчлах зорилгоор уг өдөрлөгт Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг, Биеийн тамир, Спортын Улсын хороо, Спортын холбоод, Эрүүл мэндийн хөгжлийн зуун явуулын эмнэлэг, ШУТИС-ийн хоол судлалын баг бүхий нийт 80 гаруй хүний бүрэлдэхүүнээр ажиллалаа. Уг багийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан, эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар ахлан, батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулав. Мөн ЭМХХ албаны дарга О.Чимэдсүрэн, референт Б.Батбаяр, Б.Мэндбаяр, С.Жаргалсайхан нар хамтран ажиллав.

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 20 сумдын засаг дарга, Цагдаагийн газар, ЕБС-ийн захирлууд, Сумын эрүүл мэндийн төвийн дарга нар болон албан байгууллагуудын удирдлагын баг зэрэг 150 гаруй төлөөлөл, иргэд, олон нийтийн төлөөлөл нийт 450 орчим хүнийг хамруулан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнийг танилцуулан Эрүүл Баянхонгор аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, арга зам, иргэдийн оролцоо, саналыг сонсон хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

ШУТИС-ын дэд профессор Д.Пүрэвжав аймгийн ЕБС-ийн багтай хамтран сурагчдын үдийн хоол хөтөлбөр, зохистой хооллолтын талаар танилцуулан сургуулийн захиралууд, эмч нарын баг, аймгийн удирдлагын багийн 60 гаруй төлөөллийг үдийн хоолны үзэсгэлэн, хоолны амталгаа, сургалт зэрэгт хамрууллаа.

Аймгийн хүн амын дунд түгээмэл тохиолдож буй сэргийлж болох эмгэгийн эрсдэлт хүчин зүйлс, архи тамхины хэрэглээний өнөөгийн суурь үзүүлэлтийг тодорхойлох цогц судалгааг эхлүүлж, Эрүүл Баянхонгор, эрүүл сум, эрсдэлгүй өрх, эрүүл сургууль, эрүүл хамт олон зэрэг олон талт, зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэхээр ярилцан нээлттэй өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан болно.

ХОЁР. ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

(СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ)

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ерөнхий захирал В.Баярмаа, НЭМЭШСГХ-ТСМТАлбаны дэд захирал Н.Алтанзул, тус албаны архи, донтолтын асуудал хариуцсан мэргэжилтэн, зөвлөх эмч С.Мөнхтуяа, мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Гантулга, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан

мэргэжилтэн Э.Тамир, ДЭСК-ийн үзлэгийн эмч Д.Баттөр, жолооч Баасанлхүндэв нарын 7 хүний бүрэлдхүүнтэй баг очиж ажиллан тус тусын үүрэгт ажлаа хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга зам, мөн архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулахад салбаруудын оролцоог эрчимжүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэгийн нээлт 2022.10.04-ний өдөр 08.30-12.30 хүртэл Тэмүүжин театрт үргэлжилж СЭМҮТ-ийн Ерөнхий захирал, АУ-ны доктор В.Баярмаа илтгэл тавьсан.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрат иргэдтэй уулзалт хийж, мэдээлэл өгөн, иргэдтэй санал солилцон ажилласан. 13.00 цагаас Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар “Оготонтой булаг” газар нээлттэй өдөрлөгийн үйл ажиллагаанд багаар ажиллаж үзлэгийн эмч Д.Баттөр иргэдэд үзлэг хийх, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан. Архи, согтууруулах ундааны хэрэглээг илрүүлэх CAGE сорилыг 96 хүнээс, AUDIT сорилыг 23 хүнээс авч, богино хугацааны зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Мөн “Согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзаж сурцгаая”, “Таны хүүхэд хуруугаа хөхөж байна уу”, “Хүүхэд стресст өртдөг үү?”, “Сэтгэл гутрал”, “СЭМҮТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 24 цагийн зөвлөгөө мэдээлэл хүргэдэг 1800-2000 утас”, “Архинд донтох эмгэгийн өвөрмөц эмчилгээ-Алкобус-ДИЗ”, “Өсвөр үеийхний мансууруулах бодисын хэрэглээ” зэрэг 7 төрлийн 4800 ширхэг санамж, мэдээлэл тарааж өгч ажилласан.

Баянхонгор аймгийн Жаргалан төвийн “Аялгуу” рестораны хурлын танхимд 15:00 цагаас Эрүүл мэндийн төвийн 20 өрх, сумдын эрхлэгч эмч нар, нийгмийн ажилтануудад салбар дундын сургалт зохион байгуулагдаж АУ-ны доктор Н.Алтанзул, “Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, стресс менежмент” АУМагистр С.Мөнхтуяа, “Архинд донтох эмгэгийн тухай ойлголт, тусламж үйлчилгээний орчин үеийн чиг хандлага”, Ж.Гантулга, “AUDIT сорилоор архины хэрэглээний түвшин тодорхойлох, арга” тус тус сэдвүүдээр илтгэж цэцэрлэг, сургууль, албан байгууллага, ажлын байранд урьдчилан сэргийлэх ажлыг яаж зохион байгуулж, тогтмол үйл ажиллагаа явуулж байх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

2022.10.05-ны өдөр Жаргалан төвийн “Аялгуу” рестораны хурлын танхимд 15:00 цагаас Эрүүл мэндийн төвийн 20 сумдын эрхлэгч, нийгмийн ажилтануудад салбар дундын сургалтыг үргэлжлүүлэн Ж.Гантулга, “Сургалт: Архи согтууруулах ундааны хэрэглээг судлах арга зүй”, АУМагистр С.Мөнхтуяа, “Архины хэрэглээтэй хүнд эрсдэлийн түвшинд тохирсон зөвлөгөө өгөх”, Тэргүүлэх зэргийн их эмч Д.Баттөр, “АА, өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааны туршлага”, Жаргалтай амьдрал төвийн сэтгэл зүйч “Баянхонгор аймаг дахь архины хамааралтай хүмүүст үзүүлж буй тусламж үйлчилгээний туршлага” сургалт хийлээ. Мөн стресс тайлах, тайвшруулах дасгал зааж дагаж хийлгүүлэх, сургалтын үеийн алжаал тайлах хөдөлгөөнт дасгал хамтран хийсэн нь сонирхолтой үр дүнтэй болллоо. Сургалтын үеэр болон дараа бүлгийн хэлэлцүүлэг, дүгнэлт ярилцлага, санал хүсэлт авч сургалтаа зохион байгуулсан.

Архи, согтууруулах ундааны хэрэглээний сорилыг богино хугацаанд хамт олны дунд эрт илрүүлэх аргыг зааж, эрүүл мэндийн үзлэг оношлогоотойгоо холбох, өрхийн түвшинд архинд донтох эмгэг оношийг тавьж эрт илрүүлэх, архи, тамхины хэрэглээний асуумжыг бусад үзлэгийн стандарт асуумжуудтай хамт хэрэглэж сурахыг зөвлөсөн. Үүний үр дүнд сумын иргэдийг халдварт бус өвчний эрсдэлийн гол шалтгаан архи, согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглээнээс татгалзуулах, бууруулах улмаар артерийн даралт ихдэлт, зүрх судасны эмгэг, чихрийн шижингийн 2-р хэлбэр, хавдрын хүндрэл зэрэг өвчин эмгэг үүсэх хүндрэлээс 60-80 хувиар сэргийлж болохыг зөвлөв.

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн өдөрлөг, сургалтын үеийн зургийн цомгоос:



Зураг 1: “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээний үеэр болон СЭМҮТ-ийн Ерөнхий захирал, АУ-ны доктор В.Баярмаа “Архины хэрэглээний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд” илтгэл тавьж байгаа нь





Зураг 2: Баянхонгор аймгийн иргэд, олон нийттэй уулзалт хийх үеэр:





Зураг 3: Баянхонгор аймгийн Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар “Оготонтойн булаг” газар нээлттэй өдөрлөгийн үйл ажиллагаанд багаар оролцож байгаа нь



Зураг 4: 2022.10.04, 05-ны өдрүүдийн Эрүүл мэндийн төвийн эмч, эрхлэгч, нийгмийн ажилтануудад салбар дундын сургалтыг СЭМҮТ-ийн АУДоктор Н.Алтанзул, зөвлөх эмч, АУМагистр С.Мөнхтуяа, их эмч Ж.Гантулга, тэргүүлэх зэргийн их эмч Д.Баттөр нар явуулж байгаа нь.

(НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ)

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга зам, мөн архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулахад салбаруудын оролцоог эрчимжүүлэх зорилгоор “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” өдөрлөг 2022 оны 10 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа. Тус өдөрлөгийн хүрээнд ЭМЯ-ны ХБӨ-ний хэлтсийн ахлах шинжээч Б.Туяа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Захирал С.Өнөрсайхан, Эрүүл мэндийг дэмжих өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны дарга

С.Гэрэлмаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Нарангэрэл, Б.Бүжидмаа, Г.Бадамцэцэг, Хоол судлалын албаны дарга С.Баясгалан, Д.Ганболор нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллав. Багийн бүрэлдэхүүн Баянхонгор аймгийн удирдлага, ард иргэдтэй уулзалт ярилцлага хийж, чиглэл тус бүрээр мэргэжлийн байгууллагуудад сургалт явуулж, эрүүл мэндийн үзлэг зөвлөгөө өгч, эрүүл шим тэжээлт хоол хүнсний зөвлөгөө өгөх зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Үйл ажиллагаа-1: Төр захиргааны удирдлагуудтай хийх уулзалт хэлэлцүүлэг

Уулзалт хэлэлцүүлэгт /төвөөс/ ЭМЯ, БШУЯ, Цагдаагийн Ерөнхий Газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын Үндэсний телевиз, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Нийгмийн Эрүүл Мэндийн хүрээлэн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн Наркологийн эмнэлгээс нийт 90 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг, /аймгаас / аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ын удирдлага, 20 сумын удирдлага, сургууль эмнэлгийн байгууллагын төлөөллүүд оролцов.

Удирдлагын бүрэлдэхүүний уулзалт хэлэлцүүлгийн үеэр Монгол улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан - “Эрүүл Монгол Хүн” хөдөлгөөний үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга замын тухай, НЭМҮТ-ийн захирал ХУ-ны Доктор, Профессор С.Өнөрсайхан – Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн зүйлс сэдвээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Спорт бодлогын зөвлөх М.Болд - Спорт ба эрүүл мэнд сэдвээр, Хоол зүйч, доктор, дэд профессор М.Пүрэвжав - Хүн амын хооллолт ба шим тэжээл, эрүүл мэнд сэдвээр олон улс болон манай улсын төвшинг харьцуулсан судалгаа мэдээллийг танилцуулж орон нутгийн түвшинд бодит нөхцөл байдлын судалгааг гаргах аргачлал, хэрэгжүүлэх арга замд орон нутгийн төлөөллийг сургаж ажиллана гэв.





Үйл ажиллагаа 2: Иргэдтэй хийх уулзалт, хэлэлцүүлэг

“Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний нэгдсэн арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, аймгийн ИТХ, ЗДТГ-аас холбогдох талуудтай хамтран иргэдтэй уулзалт 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 10:30-12:00 цагын хооронд зохион байгууллаа. Иргэдтэй хийх уулзалтыг Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат, Засаг дарга Д.Мөнхсайхан, Монгол улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан, Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар нээж, үг хэллээ.

Тус уулзалтаар Монгол улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх Т.Мөнхсайхан - “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөн хамрах хүрээ, хэрэгжүүлэх ажлууд, Сэтгэцийн нийгмийн сэргээн засах эмчилгээний “Жаргалтай амьдрал” төвийн эмч М.Мөнхсүлд – Орон нутгийн туршлага, архинд донтох эмгэгийг эмчилгээ хяналт зэрэг сэдвээр мэдээллийг танилцуулж эмчлүүлж эдгэрсэн иргэд санал, сэтгэгдэл, туршлагаа олон нийттэй хуваалцсан үр дүнтэй уулзалт болсон. НЭМҮТ-ийн Захирал С.Өнөрсайхан архины хор уршгийн талаар асуусан иршэдийн асуултанд хариулт өгсөн.



Үйл ажиллагаа 3: Нээлттэй хаалганы өдөрлөг

“Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 14:00-17:00 цагийн хооронд Оготнотой булгийн Крикетийн талбайд зохион байгуулагдлаа. Нээлтэй хаалганы өдөрлөгт хамтрагч байгууллагууд аймгийн ард иргэдэд, артерийн даралт, ЗСӨ-ний эрсдэлийн үнэлгээг 54 хүнд, Биеийн ерөнхий үзүүлэлт, БЖИ тодорхойлж зөвлөгөө өгсөн 62 хүн, эрүүл зөв хооллолтын зөвлөгөө 55 хүнд, дасгал хөдөлгөөн, эрүүл зөв дадал, эрүүл амьдралын хэв маягыг хэвшүүлэх талаар зөвлөгөө 86 мэдээлэл өгч, Сургалт сурталчилгааны 7 төрлийн 250 ш брошур, гарын авлага тарааж иргэдэд мэдээлэл өгсөн.

ГУРАВ. ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ (ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ)

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд үзэсгэлэн гаргаж шинэ ногооны шүүс, смүүти бэлтгэн амталгаа хийв. Тус арга хэмжээнд зохион байгуулсан үзэсгэлэнд:

1. Өргөн хэрэглээний хоол хүнсэнд агуулагдах өөх тос, ханасан өөх тос, элсэн чихрийн агууламж болон хоолтой холбоотой зарим өвчний талаар биет үзүүлэн болон хялбаршуулсан үзүүлэн, холбогдох ном, гарын авлагыг байршуулж, иргэдэд зөвлөгөө өгөв.
2. Цэцэрлэг, сургуулийн хоолны үйлчилгээнд ялгаатай байх үйлчилгээг харуулсан 10 гаран үзүүлэн, өргөн хэрэглээний нэг удаагийн сервинг хэмжээ ба илчлэгийн үзүүлэлт бүхий 15 хоолны модел дэлгэн харуулав.

Тус арга хэмжээнд зохион байгуулсан амтлагаанд 3 төрлийн бүтээгдэхүүн бэлтгэв. Үүнд:

- Бууцай, гадилтай смүүти
- Луувангийн шүүс
- Байцай, алимны шүүс

Шүүс болон смүүти бэлтгэхдээ жижиг оврын тоног төхөөрөмж ашигласан ба нэг хүнд 80-150 мл цэвэр смүүти, шүүсээр үйлчилж, амталгаа хийв. Иргэдийн хувьд ногоогоор бэлтгэсэн дээрх ундаа, шүүсийг өмнө нь амсаж байгаагүй тухайгаа илэрхийлж байгаа нь хүн амын хоол шим тэжээлийн боловсролын түвшин нэн доогуур байгааг илтгэж байна. Энэ удаагийн үйл ажиллагаанд 130 орчим иргэн үйлчлүүлэв.

Баянхонгор аймгийн Эрдэнэмандал ЕБС нь БШУЯ, UNICEF хамтран хэрэгжүүлсэн төсөлд хамрагдаж, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадавхижуулах сургалтанд хамрагдсан тул тухайн сургуультай хамтран, тодорхой төсвийн хүрээнд сургуулийн үдийн хоолонд үйлчилж буй хоолны үзэсгэлэн гаргаж, хоолоор үйлчлэв. Хоолны үйлчилгээнд ЭМХ үндэсний хөдөлгөөний холбогдох хүн болон аймгийн бүх ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан 90 гаруй хүн хамрагдав. Хоолны төсвийг 30 хүнийг ерөнхийлөгчийн тамгийн газраас, 60 хүнийг аймгийн ЗДТГ-аас хариуцсан болно.

1500 төгрөгний төсөвт багтах 5 өдрийн иж бүрдэл хоолны үзэсгэлэн сонирхолтой байсан бөгөөд мягмар гаригийн хоолоор зочдыг үйлчилсэн бөгөөд 1-5 ангийн хүүхдийн хувьд хоол ямар түвшинд байж болох талаар мэдээлэл хүргэж чадсан нь гол үр дүн юм. Хоолны үндсэн шимт бодис болон илчлэг, үнийн мэдээллийг харуулсан. Зах зээл дэх үнийн өсөлт зэрэг олон шалтгаанаас үүдэн хоногийн хоолоор авах ёстой шимт бодисын хэмжээг өнөөдрийн төсвийн хүрээнд дунджаар 70%-тай хангаж байна. Энэ нь хоолны өнөөдрийн төсөв 100% хүргэж, нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хоолны үйлчилгээнд хамрагдсан нийт захирал, нийгмийн ажилтнуудтай ярилцаж, сонирхсон асуултанд хариулав. Захирлуудын хувьд тогооч мэргэжлийн хүний нөөцийн хомсдол үүссэн, энэ нь хэт бага цалинтай холбоотой болохыг онцолж байв.

2022 оны 10 дугаар сарын 05 -ны өдөр Аймгийн Боловсролын хэлтэстэй хамтран сургуулийн захирал, нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулав. Сургалтанд:

- НҮБ-аас сурагчийн үдийн хоолны асуудлыг ямар түвшинд авч үзэж буй сүүлийн үеийн мэдээ, баримт, олон улсын туршлага, үр дүн
- ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд хэрэгжих үйлчилгээний гол арга хэмжээ, одоогоор хэрэгжиж буй зарим үр дүнгийн талаар
- Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тухай, түүний хүрээнд хийгдэх олон арга хэмжээ, боломжийн талаар
- Энэ удаагийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих онлайн судалгааны тухай тайлбар зэрэг багтсан болно.

Түүнчлэн тус аймгийн Аймгийн хэмжээний бүх Ерөнхий боловсролын сургуулиа Гүүгл форум онлайн судалгаа авав.

Аймгийн төвд 6 төрийн өмчийн ЕБС, 2 хувийн өмчийн ЕБС, 2 цэцэрлэг, бага сургуулийн комплекс үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс 5 сургуулийн Хоол үйлдвэрлэлийн байдалтай танилцлаа. Үүнд:

- Номундалай сургууль- 1200 хүүхдийн хүчин чадалтай, 2020 онд ашиглалтанд орсон шинэ хичээлийн байртай, хичээлийн байранд хоол үйлдвэрлэл зөв төлөвлөгдсөн гэж үзэж болно. Гэхдээ агуулахын хэсгийг илүү төлөвлөснөөс ашиглалтгүй талбай их байна. Багш ажиллагсадын хоолыг бэлтгэх зорилгоор гал тогооны хэсгээс түрээслэсэн бөгөөд энэ нь тус хоолны газрын үйлчлүүлэгчийн сав угаалгын хэсэг байна. Энэ талбайг бусдад түрээслүүлснээс үүдэн сав угаалга халуун цех дотроо байгаа нь технологийн урсгал зөрчигдсөн байна. Хооллох танхим нийт сурагчийн тоотой харьцуулбал хүчин чадалд хүрэхгүй тул цаашид түрээсийг зогсоох, гал тогооны өрөө тасалгааны байршлыг өөрчлөн, сав угаалга, агуулахыг зөв төлөвлөн, хооллох танхимын талбайг нэмэгдүүлэхийг эрмэлзэх шаардлагатай гэж үзлээ. 100 хүүхдийн дотуур байранд 120 хүүхэд амьдарч байлаа, тусдаа гал тогоо ажиллаж байна. Гал тогоо шаардлага хангахгүй тул цаашид сургуулийн үндсэн гал тогоотой үйлчилгээг нэгтгэх нь оновчтой. Гал тогоонд автомат тоног төхөөрөмж байхгүй, гар ажиллагаа зонхилж байгааг

өөрчлөх шаардлагатай. Сургуулийн гал тогоонд 5 тогооч, дотуур байранд 3 тогооч ажиллаж байна.

- Эрдэнэмандал сургууль: Хоол үйлдвэрлэл дотуур байрны гал тогоонд хэрэгждэг. Дотуур байр өнгөрсөн онд ашиглалтанд орсон, 100 хүүхдийн хүчин чадалтай. Гал тогооны зохион байгуулалт буруу тул дотуур байрны болон сурагчийн үдийн хоол үйлдвэрлэл явуулах боломжгүй гэж үзэж байна.
- Эрдэнэ сургууль: дотуур байргүй, сургуулийн үдийн хоолыг зоорийн давхарт байрлах, шаардлага хангахгүй байранд түрээслэгч үйлдвэрлэдэг. Байр шаардлага хангахгүй гэдгээ бүрэн ойлгодог бөгөөд 250 хүүхдийн өргөтгөл барихаар төлөвлөгдөж байгаа байран гал тогоо төлөвлөж байгаа юм байна. Захирлын зүгээс шинээр төлөвлөж буй гал тогооны зураг дээр зөвлөгөө авахыг хүссэн болно. Барилгын төлөвлөлт зурагтай танилцахад гал тогоо хүчин чадалд хүрэхгүй, технологийн алдаатай байлаа. Зураг хараахан батлагдаагүй тул зургийг өөрчлөх бүрэн боломжтой тул дахин уулзахаар тохирлоо.
- V дугаар сургууль: Энэ хичээлийн жилээс үйл ажиллагаа эхлүүлсэн шинэ сууршлын бүс дэх 630 хүүхдийн сургууль. Гал тогооны үйл ажиллагаатай танилцахад түрээсгүй ажиллаж байгаа, хооллох зал маш жижиг, үйлдвэрлэлийн урсгал буруу, хүнс хүлээн авах, хадгалах боломжгүй, ажиллагсадын хувцас солих, ариун цэврийн өрөө буруу байрлалтай зэрэг олон зөрчилтэй байна. Цаашид гал тогоог сургуулийн байрандаа өөр байршилд шилжүүлэх боломжийг судлан, дахин уулзаж, хамтран ажиллахаар ярилцлаа.
- Соого- Сейки сургууль: Сургуулийн байр хуучирсан, гал тогооны байр шаардлага хангахгүй, хэцүү нөхцөлд ажиллаж байна. Түрээсийн гал тогоо ажилладаг. Энэ байдлаа сургуулийн удирдлага маш мэдэж байгаа. 630 хүүхдийн шинэ байр төлөвлөгдөж байгаа. Шинэ байранд төлөвлөгдөж байгаа гал тогооны төлөвлөлт талаар дахин ярилцах зорилгоор уулзсан. Захирал барилгын зургаа авчирч дахин төлөвлөлт хийхээр тохирлоо.
- Нийт сургуулиудын хувьд шинэ болон хуучин аль ч байранд агааржуулалтын системийн ажиллагаа маш муу байгаа нь цаашид эрсдэл үүсгэхээр байгааг цаашдын ажилд тусгаж, анхаарах шаардлагатай болохыг тайланд тусгаж байна.

ДӨРӨВ. НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР (БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРОО)

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан нээлттэй өдөрлөгт МУ-ын Ерөнхийлөгчийн Спортын зөвлөх М. Болд, Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга О. Баасан, Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Д. Соёлмаа, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн С. Мөнх-Эрдэнэ, Монголын үндэсний олон нийтийн телевизийн спортын сэтгүүлч Д. Батжаргал, Г. Бүрэнбилэг Илтгэгч А.Тэнгис, хөтлөгч, бүжгийн продюсер Н. Мөнгөтулга, Үндэсний биелгээний багш Б. Сайханбилэг болон Монголын хөл бөмбөгийн шигшээ баг, Монголын сагсан бөмбөгийн 3*3 сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчид, шүүгч, судлаач зэрэг 49 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаа.

Тус өдөрлөгийн хүрээнд Хөл бөмбөгийн "Грассрүүтс" сургалт, Хөл бөмбөгийн фестиваль, Сагсан бөмбөгийн 3х3 сонирхогчдын тэмцээн, идэвхтэй хөдөлгөөний флэш моб зэргээс гадна сумын арга зүйч нарийн сургалтыг зохион байгуулав. Эдгээр арга хэмжээнд нийт 489 хүн хамрагдсан дүнтэй байна.

Нийтийн биеийн тамир

1. Хөл бөмбөгийн фестиваль: 80 хүүхэд
2. Сагсан бөмбөгийн 3х3 сонирхогчдын тэмцээн: 150 тамирчин
3. Идэвхтэй хөдөлгөөний флэш моб-д 300 хүн

Сургалт

1. Хөл бөмбөгийн "Грассрүүтс" сургалт: Баянхонгор аймгийн 20 багш, 120 хүүхэд хамрагдав
2. Сумын биеийн тамирын арга зүйч нарын сургалт: Баянхонгор аймгийн 19 сумын биеийн тамирын арга зүйч хамрагдав

"Эрүүл Монгол хүн" өдөрлөгөөс шуурхай мэдээ, сурвалжлаг бэлтгэж 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн "Цаг хүрд" мэдээллийн хөтөлбөрийн "спортын мэдээ"-ээр гаргав.

Мөн 2022 оны 10 дугаар сарын 10-14-ны өдрийн 20 минутын нэвтрүүлэг бэлтгэн гаргана. Баянхонгор аймгийн идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамираар хичээллэж "илүүдэл жингээ хассан 1 иргэн", "харвалтын дараа идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүлжсэн 1 иргэн", "идэвхтэй хөдөлгөөнөөр чихрийн шинжин өвчнөөс ангижирсан 1 иргэн" жишээгээр контент бэлтгэн олон нийтэд түгээв. Үргэлжлүүлэн контентыг түгээх, сурталчилгааны ажил хийхээр төлөвлөөд байна.

Цаашид бид нийтийн биеийн тамирын чиглэлд дараах үйл ажиллагааг төлөвлөөд байна. Үүнд:

1. Нийтийн биеийн тамирын чиглэлээр Суурь судалгаа гаргах,
2. Нийтийн биеийн тамир, идэвхтэй дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах, мэдлэг олгох ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг хянах, үр дүнг дүгнэх,
3. Тодорхой хугацаанд идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг хүний тоог нэмэгдүүлэх,
4. Нийтийн биеийн тамир, идэвхтэй дасгал хөдөлгөөнтэй холбоотой аливаа ажил, үүрэг даалгавар, амлалт, аян, төсөл хөтөлбөр гэх зэргийг зохион байгуулах цаг хугацаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдуулах, хянах, дүгнэх,
5. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулиуд, их дээд сургуулиуд, "Монголын оюутны холбоо", "Монголын залуучуудын холбоо" гэх зэрэг байгууллагуудыг "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөнд татан оролцуулах, хянах, дүгнэх,

6. Нийгмийн сүлжээнд олон дагагчидтай 1000 залуусын жагсаалтыг гаргаж, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнд сайн дурын үндсэн дээр татан оролцуулах, нөлөөллийн ажлыг хянах, дүгнэх,
7. Монголын 70 гаруй спортын холбоодтой хамтран “нийтийн спорт”-ыг хөгжүүлэх, хамтарсан арга хэмжээ зохион байгуулах, холбоодоор дамжуулан олон нийтийг уриалах нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хянах, дүгнэх;

**ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
(УЛСЫН ТӨВ НЭГДҮГЭЭР ЭМНЭЛЭГ)**

Баянхонгор аймагт Улсын төв нэгдүгээр эмнэлгээс Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Доржханд, мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч Б.Дагважанцан, Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал.Б.Түвшинтөр, Бөөрний төвийн зөвлөх эмч Х.Чулуунцэцэг, Эмнэлзүйн албаны дарга Л.Ундармаа, Эм зүйн албаны дарга С.Уянга, Техникийн албаны дарга С.Учрал, Уушги харшил судлалын төвийн дарга Б.Одончимэг, Мэдрэлийн эмнэлзүйн төвийн их эмч Б.Саруулцэцэг Зүрхний төвийн их эмч Б.Тайхар, Чих хамар хоолой судлал, мэс заслын тасгийн их эмч Э.Золцэцэг Дотоод шүүрэл судлал диабетийн төвийн их эмч Б.Золбоо, Гастрэнтерологийн төвийн их эмч Д.Ариунзул, Дүрслэл оношилгооны төвийн их эмч Д.Эрдэнэцэцэг, Зүрхний төвийн их эмч Д.Даваадалай нарын бүрэлдэхүүнтэй ажиллав.

Үзлэгт хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр илэрхийлэв

№	Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг	Үзлэгийн тоо
1	Мэдрэл	51
2	Бөөр	78
3	Чих хамар хоолой	50
4	Дотоод шүүрэл	80
5	Хоол боловсруулах	68
6	Зүрх, судас	
7	Зүрхний ЭХО	33
8	Уушги	60
9	Дүрс оношилгоо/ЭХО,ЭКГ/	123
10	Бодисын хордлого	1
11	Цусны хавдар	3
	Нийт	650

Улсын нэгдүгээр төв эмнэлэг “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 10 сарын 04-06-ны хооронд Баянхонгор аймагт ажиллаж 9 чиглэлээр лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ, 5 чиглэлээр дэмжин туслах үйлчилгээ үзүүлсэн. Дээрх хугацаанд давхардсан тоогоор 650 хүнд үзлэг оношилгоо хийгдсэн байна. Бөөрний хавдар-2, Элэгний хавдар 2, ходоодны хавдар 1 хүн тус тус шинээр оношлогдсон бол баруун хөлийн артери судас бөглөрсөн-1, зүүн талын гүрээний венийн судасны бөглөрөл -1 тус

тус оношлон УНТЭ рүү яаралтай шилжүүлсэн. Баянхонгор аймаг нь агаарын бохирдол ихтэй,уул уурхайн салбарт ажилладаг иргэд их байдаг тул уушгины өвчлөл ихтэйд тооцогддог. Залуу насны эрэгтэйчүүд пневмокониоз, силикоз оношлогдон хөдөлмөрийн чадвар алдах, амь насаа алдах явдал цөөнгүй байдаг. Зүрх судасны эмгэг болон амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг зонхилон тохиолдож байсан.

Үүнээс: Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг

1. Гуурсан хоолойн бөглөрөлт өвчин
2. Уушигны архаг бөглөрөлт өвчин
3. Гуурсан хоолойн багтраа
4. Уушгины завсрын эдийн хатуурал
5. Ханиалгалт

Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг

1. Элэгний хатуурал
2. Нойр булчирхайн архаг үрэвсэл
3. Цэсний хүүдийг архаг үрэвсэл
4. Ходоодны шархлаа

Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг

1. Артерийн даралт ихсэх өвчин
2. Зүрхний хэм алдалт
3. Зүрхний архаг дутагдал
4. Зүрхний архаг ишемит өвчин

Чих хамар хоолойн эмгэг

1. Хамрын таславч мурийх эмгэг
2. Тагнайн гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл
3. Харшилын гаралтай архаг ринит
4. Дунд чихний архаг идээт бус үрэвсэл
5. Мэдрэлийн гаралтай сонсгол бууралт

Дотоод шүүрлийн эмгэг

1. Чихрийн шижин
2. Хордлогогүй бэрсүүт бахуу
3. Бамбай булчирхайн хордлого
4. Бамбай булчирхайн дутагдал
5. Бамбай булчирхайн үрэвсэл зонхилон тохиолдож байна.

Эрүүл мэндийн даатгал, цахим өвчний түүх хөтлөлт, эм болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтанд техник технологийн үнэлгээ хийж ашиглагдахгүй байсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулсан. Үүнд ходоодны дурангийн шинжилгээнд 5 хүн, уушигны дурангийн шинжилгээнд 3 хүнийг хамруулсан.

Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгийн Инженер техникийн албаны инженерүүдтэй хамтран эмнэлгийн серверийн өрөө болон ашиглаж буй e-health системийн тохиргоо, ажиллагааг шалгаж тохиргоонууд хийгдсэн. Програмд бүртгэгдсэн бүртгэлүүд 1 хоногоор зөрж байсан алдааг зассан. Мөн Даатгал статистикийн эмч, бага эмч, чанарын албаны мэргэжилтнүүд, эмзүйн албаны эмзүйч, сувилахуйн албаны аргазүйч нарт e-health програмын ашиглалтын талаарх сургалт хийгдсэн. Нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдад “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилт, тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд анхаарах асуудлууд, буцаагдсан нэхэмжлэл”-ын талаар сургалт зохион байгуулж, харилцан ярилцлага зохион байгууллаа.



Мөн Нэгдсэн эмнэлгийн Статистик мэдээллийн албаны хамт олонд програмд хэрхэн зөв бүртгэл хийх, алдаагүй нэхэмжлэх, хасагдал, түүний шалтгаануудын талаар ажлын байрны дадлага, сургалтыг хийлээ. Сургалтын үр дүнд аймгийн нэгдсэн эмнэлэг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн орчинд оновчтой ажиллаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн нөөцийн ашиглалтаа сайжруулах, эмнэлгийн гүйцэтгэлээ сайжруулах талаар нэгдсэн нэг ойлголттой болж, шинэчлэл амжилттай хэрэгжих үндэс суурь болно.

Баянхонгор аймгийн мэдрэлийн тасгийн эмч Тунгалагийг тархины судасны дуплекснографигаар сургахаар зөвшилцөн УНТЭ-ийн МЭТ-д сургахаар болсон. Цаашид эмч эмнэлгийн мэргэжилтэн солилцох, эмнэлзүйн чиглэлээр ажлын байран дээрх сургалтуудыг зохион байгуулах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулан боловсон хүчнийг бэлтгэх, эрт илрүүлэг оношилгоо шинжилгээнд иргэдийг хамруулахад хамтран ажиллахаар болов.

(ХӨГЖЛИЙН ЗУУН ТӨРИЙН БУС БАЙГУЛЛАГА)

Тус байгууллага нь Баянхонгор аймагт гүцэтгэх захирал Сүхзориг, төслийн менежер Тунгалагсайхан, төслийн менежер Б.Алтанхуяг хүүхдийн эмч Н.Дарьсүрэн, шүдний эмж Б.Батбаяр, гишүүн Л.Намхайноров, Б.Алтангэрэл нарын бүрэлдэхүүнтэйгээр үзлэг, шинжилгээний ажил хийж гүйцэтгэв

Явуулын хоёр эмнэлэг:

Баянхонгор аймгийн иргэдэд нарийн мэргэжлийн эмч нарын /Зүрх, дүрслэл оношилгоо, шүд/ үзлэг, оношилгоо хийв. Тус үзлэгт нийт 346 иргэн хамраглаа.

Шүдний үзлэгийн хүрээнд нийт 124 хүнд үзлэг хийснээс Шүдний өнгөц цоорол ихэнх хувийг эзэлж байна. Энэ нь нүүрс усны агууламжтай хоол хүнс ихээр хэрэглэснээс үүдэлтэй. Үүнд: Чихэр, пичень,сахар, гурилан бүтээгдэхүүн орно. Мөн Амны хөндийн ариун цэвэр сайн сахих шаардлагатай байгааг харуулж байна.

Анхаарах: Шүдний эмчилгээг анхан шатанд нь эмчлэхгүйгээр шууд авхуулсан тохиолдол их байгаа нь шүд эрүүний гажиг үүсэх зэрэг хүндрэлүүдийг үүсгэсэн тохиолдол их байна.

Хэвлийн эхо, Зүрхний цахилгаан бичлэг 284 хүнд хийхэд Зүрхний томрол, таргалалт хэм алдалт, Бамбай булчирхайн өөрчлөлттэй хүмүүс их байв.



Явуулын эмнэлгийн үзлэг

Сургалт – хөтөлбөр, хамруулсан хүний тоо

Сургалт 1:

“6 настай хүүхдийн зүрхний эмгэг илрүүлэг, хяналт” – төслийн бэлтгэл ба сургалт

1. Судалгааны арга, аргачлал боловсруулах, батлуулах:

АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хороонд танилцуулж, Судалгааны ажлын сэдэв, аргачлалыг 2022 он 01 сарын 18-ний өдрийн Анагаах ухааны сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимээр хэлэлцүүлэн батлуулсан тул судалгааг явуулах ёс зүйн зөвшөөрөл авсан.

Судалгааны загвар ба арга зүй:

- Хүүхдийн эрүүл мэндийн үнэлгээ:
 - Сургууль, цэцэрлэг ба өрхөд суурилсан-агшингийн судалгааны загвар:
- Зүрхний эмгэгийн илрүүлэг:
 - Сургууль, цэцэрлэгт суурилсан-агшингийн судалгааны загвар

Үйл ажиллагаа

- Мэдлэг шалгах сорил
- Зүрхний цахилгаан бичлэг хийх аргачлал
- Бие бялдрын үнэлгээ дадлага
- Хүүхдийн артерийн даралт үнэлэх дадлага

Анагаах ухааны сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимээр хэлэлцүүлсэн.

Оролцогчид: АНЭ, ЭМГ, ӨЭМТ, ЕБС–ийн эмч (хүүхэд хариуцсан)
ЕБС удирдлага

Сургалтын хөтөлбөр:

Хэзээ: 2022 оны 10 сарын 04 -05

Хаана: Баянхонгор аймгийн төв


Оролцогчид:

- Цэцэрлэг хот дахь ӨЭМТ, хүүхдийн эмч
- ЕБС-ийн эмч


Үйл ажиллагааны чиглэл:

- **Сургалт:**
 - Сургалтад нийт 14 эмч хамрагдав.

- **Дадлага:**
 - 2-р сургуулийн 6 хүүхэд бие бялдрын хөгжлийн үнэлгээ ба зүрхний эмгэгийн илрүүлгийн дадлага ажилд хамрагдав.
- **Сорил:**
 - Сургалтын өмнөх мэдлэг шалгах сорил
 - Сургалтын дараах мэдлэг шалгах сорил
- **Тараах материал**
 - Хүүхдийн зүрхний эмгэг эрт илрүүлэх 16 нүүр бүхий тараах материалыг 14 ӨЭМТ, ЕБС-ийн эмч, сувилагч нарт өгсөн.



Н.Дарьсүрэн хүүхдийн эмч /сургалтын үйл явц/





Хүүхдийн зүрхний эмгэг илрүүлэх дадлага ажил

Сургалт 2:

“Эрүүл мэндийг дэмжигч сургууль, сургуулийн орчны эрүүл ахуй”

Баянхонгор аймгийн ЕБС-ийн нийт 60 захирал, нийгмийн ажилтанд “Эрүүл мэндийг дэмжигч сургууль, Сургуулийн орчны эрүүл ахуйн талаар сургалт хийв.

Мөн ЕБС-ийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, хоол зүйн талаар 7 бүлэг бүхий 76 асуулттай судалгааг авч дүн шинжилгээ хийж байна.



Сургалтын үйл явц

ЗУРГАА. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (ХӨГЖЛИЙН ЗУУН ТББ)

Монгол улсын ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжиж буй Эрүүл Монгол Хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн орон нутгийн

мэдээллийн хэрэгслүүд болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд мэдээлэл хүргэн ажилласан байдлын тайлан.

Телевиз 3

1. MNB
2. Номгон ТВ
3. Баянхонгор ТВ

Цахим хуудас 6

1. Баянхонгор ЗДТГ
2. Баянхонгор БТСГ
3. Баянхонгор БШУГ
4. УНТЭ
5. НЭМҮТ гэх мэт
6. Нээлттэй засаг нэг баянхонгор

Веб сайт 6

1. Sonin.mn
2. Bayanhongor .mn
3. 24tsag.mn
4. Tur.mn

Нийт 2022.10.03-10.10 өдөрт **13** мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэн ажилласан байна.

Хүлээгдэж буй мэдээлэл:

- Баянхонгор ЭМХ контент /2 хоног/
- Баянхонгор сэтгүүл /14 хоног/



“ Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн Баянхонгор аймагт эхэллээ Монголын үндэсний олон нийтийн телевиз

2022/10/06/




“Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн 2022 оны 10 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Баянхонгор аймагт

Баянхонгор тв
10/3/2022



“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, нэгдсэн арга хэмжээ 2022 оны 10 сарын 04, 05-ны өдөр баянхонгор аймагт
Нээлттэй засаг нэг Баянхонгор

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн Баянхонгор аймагт
Монцама агентлаг 10/5/2022



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний нээлтийн үйл ажиллагаа
“Номгон тэ”

10/5/2022

Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн Баянхонгор аймаг <https://www.24tsag.mn/> 10/5/2022



Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн Баянхонгор аймагт tur.mn 10/7/2022



Дүгнэлт:

Баянхонгор аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан Эрүүл Монгол хүн- үндэсний хөдөлгөөнийг танилцуулан сурталчлах, орон нутагт эрчимжүүлэх нээлттэй өдөрлөг амжилттай явагдсан. Тус аймгийн хүн амыг төлөөлхүйц нэгжийг хамруулан эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг ЕТГ-ын ЭМХХА, СЭМҮТ, НЭМҮТ, аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулж, түүнд тулгуурлан “Эрүүл Баянхонгор” дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлэв.

Тайлантай танилцсан:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Эрүү мэнд, спорт, нийгмийн

бодлогын зөвлөх
Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Эдийн засгийн бодлогын зөвлөх

Т.Мөнхсайхан

Б.Даваадалай

Тайланг хянасан:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын
газрын “Эрүүл Монгол хүн” төсөл,
хөтөлбөр хариуцсан албаны дарга

О.Чимэдсүрэн

Тайланг нэгтгэсэн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын
газрын “Эрүүл Монгол хүн” төсөл,
хөтөлбөр хариуцсан

албаны

референт

С.Жаргалсайхан

Тайланг бичсэн:

Нийгмийн эрүүл мэндийн
үндэсний төвийн захирал

С.Өнөрсайхан,

Сэтгэцийн эрүүл мэндний
үндэсний хүрээлэнгийн захирал

В.Баярмаа

Доктор, профессор

Д.Пүрэвжав

Улсын нэгдүгээр төв
эмнэлгийн дэд захирал

Б.Доржханд

Хөгжлийн зуун төрийн бус
байгууллагын гүйцэтгэх захирал

Б.Сүхзориг